



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/23

Номгон

“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг  
2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний  
төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол улсад “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг батлах тухай Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310057

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны  
 өдрийн 1/23 дугаар захирамжийн хавсралт



ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
 АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

1	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүнд	Хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	4	5
Хүний эрх, эрх чөлөөг хөхүүлэн дэмжих, хүний эрхийн боловсрол олгох ажлын хүрээнд				
1	Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд хүний эрхийн сургалтуудыг аймгийн хэмжээнд бэлтгэгдсэн жендэрийн сургагч багш нартай хамтран зохион байгуулах	Сургалтын төрийн захиргааны байгууллагад 2, төрийн үйлчилгээний байгууллагад 2 зохион байгуулсан байна.	Эхний хагас жилд: 2 удаа, Сүүлийн хагас жилд: 2 удаа	ХЭЗХ-ийн мэргэжилтэн Б.Анухатан
2	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх видео, постер бэлтгэж иргэдэд хүргэнэ.	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх видео, постер бэлтгэж олон нийтэд 1 удаа түгээсэн байна.	2 сард	ХЭЗХ-ийн мэргэжилтэн Б.Анухатан
3	Хүний эрхийг хамгаалах Олон Улсын өдрийг тохиолдуулан сум байгууллага иргэдийн дунд аян зарлаж зохион байгуулах	Аяны хугацаанд иргэдийн хүний эрхийн талаарх мэдлэг ойлголт, хандлага сайжирсан байна.	6-10 сард	Мэргэжилтэн Б.Анухатан
4	Аймгийн хэмжээний гэмт хэрэг зөрчилд холбогдсон төрийн албан хаагчдын судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах	Цагдаагийн газраас ирүүлсэн судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Улирал бүр	ХЭЗХ-ийн мэргэжилтэн Б.Анухатан
5	Ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Сургалтыг Аймгийн Засаг даргын Тамгын газар болон захиалгат байгууллагад зохион байгуулна.	3 сард	ХЭЗХ-ийн мэргэжилтэн Б.Анухатан

1	2	3	4	5
6	Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1 сарын аян зарлах	Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1 сарын аян зарлаж үр дүнг тооцон ажиллах	4 сард	ХЭЗХ-ийн мэргэжилтэн Б.Анухатан
37	Ерөнхий боловсролын сургуулийн зөрчилд холбогдсон сурагчдын судалгаанд үндэслэн сургуулийн захирал, анги удирдсан багш нарт зөвлөмж, чиглэл өгч ажиллах	Сургуулиудын удирдлага, анги удирдсан багш нарт зөвлөмж, чиглэл хүргүүлэх	Жилдээ	ХЭЗХ-ийн мэргэжилтэн Б.Анухатан
8	Хүний зөрчигдсөн эрхийн талаарх ирүүлсэн мэдээ, судалгааг авах, хүний эрхийг хангах хамгаалах талаар арга зүйн зөвлөмжийг сумын Засаг дарга нарт хүргүүлж ажиллах	Судалгааг авч Сумдын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлж ажилласан байх	2 дугаар улиралд	ХЭЗХ-ийн мэргэжилтэн Б.Анухатан
Хүний эрх зөрчигдсөн асуудлын талаар иргэдээс ирсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар				
9	Хүний эрхийн зөрчлийн талаарх Засгийн Газрын 1111 төв өгсөн гомдолын дагуу холбогдох байгууллагад дамжуулах хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх	Хүний эрхийн зөрчлийн талаар гомдолыг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх	Жилдээ	ХЭЗХ-ийн мэргэжилтэн Б.Анухатан